



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/012-НА-СТА-ТТ3

Цахим хуудас:
www.audit.mn
Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Аудитор: Ж.Цогт
Утас: 70363036 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	9-19
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9-10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт..	10-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15-17
4. Аудитын тайлан.....	17-25
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17-18
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18-19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19-20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. Аудитын илрүүлэлт	20-24
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



БАРУУНБҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ОТГОНБААСАН ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.08.28 № СЭА-2025/012-НА-СТА-ТТЗ
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар болон санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын хүрээнд илэрсэн дараах зөрчлүүд нь ХХОАТ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, 43 дугаар зүйлийн 43.3, Нотариатын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг

журам"-ын 1.2 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчдад олгосон мөнгөн урамшууллаас хувь хүний орлогын албан татвар **1,618.2** мянган төгрөгийг суутгаагүй,
- Сумын ЗДТГ-ын даргын албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан нотариатын ажлыг гүйцэтгэсэн гэх үндэслэлээр **7,404.9** мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон,
- Сумын ИТХ нь төлөөлөгчдийн хоолны зардлыг бодит ирцээр бус нийт төлөөлөгчдийн тоогоор тооцож, **569.5** мянган төгрөг илүү зарцуулсан,
- ЗДНХ-өөс жил бүр давтагддаг, урьдчилан төлөвлөх боломжтой, сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны зардал болох тохижилтын ажил буюу нохой устгалд **3,000.0** мянган төгрөгийг зарцуулсан,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулган хадгалан үлдэх зорилгоор **4,879.6** мянган төгрөгийг зарцуулсан,
- Шилэн дансанд мэдээлбэл зохих 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,
- Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 10 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээс урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулалгүйгээр **100,000.0** мянган төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон,
- Худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэх зорилгоор **140,000.0** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий худаг гаргах төсөл, арга хэмжээг 7 төсөл, арга хэмжээ болгон хувааж, төлөвлөн хэрэгжүүлсэн,
- ЗДТГ нь шууд худалдан авах босго үнээс давсан **49,485.3** мянган төгрөгийн шатахууны худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 03-ны "2024 оны тодотгосон төсөө батлах тухай" 94 дүгээр тогтоолоор 786,980.2 мянган төгрөгийн татварын орлого, 38,200.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 1,295,450.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 148.7 хувиар биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд сумын 100 жилийн ойн баярын хүрээнд иргэд, аж ахуйн нэгжээс өөрсдийн санаачилгаар сумын угтах үдэх самбар, хүндэтгэлийн гэр, тоглоомын талбай, хөшөө, ахмадын байрны иж бүрэн засвар, суманд 8 ширхэг хяналтын камер суурилуулан бүрэн ажиллагаанд оруулж хүлээлгэн өгсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Баруунбүрэн сумын Засаг дарга нь тайлант онд 20 зорилт, 209 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 85.5 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	534,332.9	1,353,201.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	288,050.5	1,142,951.2
33	АВЛАГА	153,372.2	119,619.2
35	БАРАА МАТЕРИАЛ	92,910.3	90,631.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,009,308.0	7,566,976.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,009,308.0	7,566,976.4
39200	Биет хөрөнгө	3,985,860.8	7,248,808.5
39300	Биет бус хөрөнгө	23,447.2	318,167.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,543,640.9	8,920,178.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	71.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	71.7
41300	Өглөг	-	71.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,543,640.9	8,920,106.6
51	Засгийн газрын хувь оролцоо	4,543,640.9	8,920,106.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	278,919.3	278,919.3
51200	Хуримтлагдсан үр дүн	4,053,997.5	8,430,463.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	210,724.1	210,724.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,543,640.9	8,920,178.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,705,752.0	7,242,873.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	620,759.2	1,149,377.1
110	Орлогын албан татвар	279,282.6	526,190.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	310,432.8	551,803.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(31,150.3)	(25,612.8)
113	Хөрөнгийн албан татвар	235,399.1	226,049.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	106,077.6	397,136.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,053,035.9	4,264,028.3
120	Нийтлэг татварын бус орлого	2,053,035.9	4,264,028.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,031,956.9	1,829,468.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,854,184.3	2,393,023.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,758,968.6	2,393,023.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,722,275.8	2,306,814.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	659,913.4	891,717.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,421.1	109,265.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,261.2	414,517.2
2104	Хангамж, бараа материалын зардал	78,252.9	86,153.7
2105	Нормативт зардал	490.4	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,397.2	133,038.0
2107	Томилолт, зочны зардал	11,727.5	13,705.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	413,340.6	25,058.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	375,471.5	633,358.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,692.8	86,209.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	95,215.7	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,851,567.7	4,849,850.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	763,749.8	473,384.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,087,818.0	4,376,465.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,455,823.0	3,455,823.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,455,823.0	3,455,823.0
9	Тайлант үеийн үр дүн	1,087,818.0	1,087,818.0
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,543,640.9	4,543,640.9
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,543,640.9	4,543,640.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,543,640.9	4,543,640.9
19	Тайлант үеийн үр дүн	4,376,465.6	4,376,465.6
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,920,106.6	8,920,106.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,814,304.1	3,225,570.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	620,759.2	1,149,377.1
110	Орлогын албан татвар	279,282.6	526,190.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	310,432.8	551,803.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(31,150.3)	(25,612.8)
113	Хөрөнгийн албан татвар	235,399.1	226,049.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	106,077.6	397,136.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,341.1	17,664.4
1181	Газрын төлбөр	31,855.5	242,991.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	63,881.0	136,481.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	161,588.0	246,724.7
120	Нийтлэг татварын бус орлого	161,588.0	246,724.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,031,956.9	1,829,468.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,465,315.8	1,823,299.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,465,315.8	1,823,299.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,428,623.0	1,737,090.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	659,913.4	891,717.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,421.1	109,265.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,261.2	414,517.2
2104	Хангамж, бараа материалын зардал	61,530.9	60,616.8
2105	Нормативт зардал	1,307.5	504.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,287.2	138,037.6
2107	Томилолт, зочны зардал	11,727.5	13,705.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	413,494.6	29,419.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,679.5	79,306.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,692.8	86,209.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	348,988.4	1,402,270.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	931,960.7	547,370.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	931,960.7	547,370.1
2200	Дотоод эх үүсвэрээр	931,960.7	547,370.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(V)-(V)	(931,960.7)	(547,370.1)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(120,000.0)	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	120,000.0	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(702,972.3)	854,900.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	991,022.8	288,050.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	288,050.5	1,142,951.2

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,029,399.3	2,364,087.6	665,311.7	78.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,063,648.0	1,890,702.7	172,945.3	91.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,977,411.7	1,805,202.3	172,209.4	91.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	922,779.1	891,717.4	31,061.7	96.6
210101	Үндсэн цалин	429,197.2	497,618.5	- 68,421.3	115.9
210102	Нэмэгдэл	334,859.3	228,246.3	106,613.0	68.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,493.0	3,130.5	2,362.5	57.0
210104	Урамшуулал	16,931.8	28,986.3	- 12,054.5	171.2
210105	Гэрээт ажлын хөлс	136,297.8	133,735.8	2,562.0	98.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,347.3	109,265.3	6,082.0	94.7
210201	Тэтгэврийн даатгал	78,436.3	75,703.3	2,733.0	96.5
210202	Тэтгэмжийн даатгал	9,227.7	8,873.3	354.4	96.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,069.4	5,702.8	17,366.6	24.7
210204	Ажилгүйдлийн даатгал	4,613.9	4,097.5	516.4	88.8
210205	Эрүүл мэндийн даатгал	-	14,888.5	- 14,888.5	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	450,351.6	414,517.2	35,834.4	92.0
210301	Гэрэл, цахилгаан	73,968.8	75,158.9	- 1,190.1	101.6
210302	Түлш, халаалт	355,186.4	307,624.3	47,562.1	86.6
210303	Цэвэр, бохир ус	21,196.4	31,734.0	- 10,537.6	149.7
2104	Хангамж, бараа материалын зардал	56,722.2	56,719.7	2.5	100.0
210401	Бичиг хэрэг	6,757.2	7,902.2	- 1,145.0	116.9
210402	Тээвэр, шатахуун	37,152.4	36,698.0	454.4	98.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,989.3	6,376.2	613.1	91.2
210405	Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000.0	3,000.0	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,823.3	2,743.3	80.0	97.2
2105	Нормативт зардал	504.0	504.0	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	504.0	504.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	175,255.5	174,891.1	364.4	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	33,197.5	33,197.5	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	714.7	714.7	-	100.0
210604	Урсгал засвар	141,343.3	140,978.9	364.4	99.7
2107	Томилолт, зочны зардал	18,154.7	13,705.9	4,448.9	75.5
210702	Дотоод албан томилолт	18,154.7	13,705.9	4,448.9	75.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	146,308.5	52,720.9	93,587.6	36.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	144,396.2	51,585.9	92,810.3	35.7
210803	Даатгалын үйлчилгээ	983.4	495.7	487.7	50.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	544.3	474.3	70.0	87.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	301.8	165.0	136.8	54.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	80.0	-	80.0	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2.8	-	2.8	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,988.8	91,160.9	827.9	99.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,988.8	91,160.9	827.9	99.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,236.3	85,500.4	735.9	99.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,236.3	85,500.4	735.9	99.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,819.0	51,353.1	465.9	99.1
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	32,364.0	32,364.0	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,053.3	1,783.3	270.0	86.9

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	838,491.3	473,384.9	365,106.4	56.5
220001	Барилга байгууламж	7,164.2	-	7,164.2	-
221001	Их засвар	400,125.7	193,965.2	206,160.5	48.5
222001	Тоног төхөөрөмж	215,000.0	165,099.0	49,901.0	76.8
223001	Бусад хөрөнгө	216,201.4	114,320.7	101,880.7	52.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	127,260.0	-	127,260.0	-
230001	Эргэж төлөгдөх зээл	127,260.0	-	127,260.0	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,029,399.3	2,590,293.7	439,105.6	85.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,772,166.7	2,489,642.1	282,524.6	89.8
320001	Орон нутгийн төсвөөс	2,164,745.3	1,892,320.7	272,424.6	87.4
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	607,421.4	597,321.4	10,100.0	98.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	257,232.6	100,651.6	156,581.0	39.1
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,429.2	100,651.6	39,777.6	71.7
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	116,803.4	-	116,803.4	-
4	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	165,993.9	- 165,993.9	
5	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	392,200.1	- 392,200.1	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	69.0	69.0	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3.0	3.0	-	100.0
610001	Төсвийн байгууллага	3.0	3.0	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	33.0	33.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	9.0	9.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.0	16.0	-	100.0
620004	Гэрээт ажилтан	8.0	8.0	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	33.0	33.0	-	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	16.0	16.0	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3.0	3.0	-	100.0
650010	Гэрээт ажилтан	8.0	8.0	-	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6.0	6.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,581.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,581.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,873.1
2104	Хангамж, бараа материалын зардал	3,897.1
210401	Бичиг хэрэг	2,232.2
210402	Тээвэр, шатахуун	1,664.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,176.0
210604	Урсгал засвар	1,176.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	800.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	708.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	708.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	708.8
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,581.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,581.9
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,773.7
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,808.2

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баруунбүрэн сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Эрчимжсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлалд түшиглэсэн бизнес нь тогтвортой хөгжсөн, иргэдийн ажиллаж, амьдрах таатай орчин бүрдсэн хөгжлийн түвшингээрээ аймагтаа тэргүүлэх сумдын нэг болох” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг баталсан,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт нь оновчтой, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

2024 онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунбүрэн сумын ТТЗ нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баруунбүрэн сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан *“Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”*-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,376,537.4 мянган төгрөгөөр буюу 50.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	288,050.5	1,142,951.2	854,900.7
Авлага	153,372.2	119,619.2	(33,753.0)
Бараа материал	92,910.3	90,631.5	(2,278.8)
Үндсэн хөрөнгө	4,009,308.0	7,566,976.4	3,557,668.4
Нийт хөрөнгө	4,543,640.9	8,920,178.3	4,376,537.4
Өр төлбөр	-	71.7	71.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,543,640.9	8,920,106.6	4,376,465.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,543,640.9	8,920,178.3	4,376,537.4

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансад бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,142,951.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 854,900.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	288,050.5	1,142,951.2	854,900.7
Төгрөг	288,050.5	1,142,951.2	854,900.7
Төрийн сангийн харилцах	288,050.5	1,142,951.2	854,900.7
Арилжааны банк дахь харилцах	-	-	
Дүн	288,050.5	1,142,951.2	854,900.7

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансанд орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 750,751.1 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 319,751.6 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 72,448.4 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 119,619.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 33,753.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	-	-	-
Зээлийн хүүгийн авлага	344.0	344.0	-
Байгууллагаас авах авлага	1,522.6	1,522.6	-
Хувь хүмүүсээс авах авлага	123,796.7	90,043.7	(33,753.0)
Хувь хүмүүст олгосон зээл	27,708.8	27,708.0	-
Дүн	153,372.1	119,619.2	(33,753.0)

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай /2013-2015 онуудад үүссэн итгэлийн зээл, татварын хөнгөлөлтийн авлага гэх мэт/ 5,589.3 мянган төгрөгийн авлага байгаагаас орон нутгийн ерөнхий орлогын 4,066.7 мянган төгрөг, ЗДТГ-ын 1,522.6 мянган төгрөгийн авлагууд бүртгэлтэй байна.

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдлийн 95.3 хувь буюу 114,029.9 мянган төгрөгийг ХХС-ийн зээл, хүүгийн авлага эзэлж байна.

Насжилт өндөртэй /3-аас дээш жил/ ХХС-ийн зээлийн 76,000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар холбогдох шатны шүүхэд хандаж, 22 иргэний нийт 76,000.0 мянган төгрөгийн нэхэмжлэлийг хүргүүлэн ажилласан байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 90,631.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,278.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	92,910.3	90,631.5	(2,278.8)
Бичиг хэргийн материал	4,705.5	4,746.6	41.1
Аж ахуйн материал	82,551.2	83,616.3	1,065.1
Сэлбэг хэрэгсэл	-	-	-
Түлш, шатах тослох материал	-	-	-
Барилгын засварын материал	-	-	-
Бусад хангамжийн материал	5,653.6	2,268.6	(3,385.0)
Дүн	92,910.3	90,631.5	(2,278.8)

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оныхоос 2,278.8 мянган төгрөгөөр буурсан нь 632,027.6 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 9,316.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй СЭА-2025/012-НА-СТА-ТТЗ

шилжүүлэн авч, 152,941.9 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулан, 473,384.9 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 7,566,976.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,557,668.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	3,985,860.8	7,188,711.7	3,202,850.9
Барилга, байгууламж, орон сууц	2,063,281.3	2,041,760.8	(21,520.5)
Авто-тээврийн хэрэгсэл	41,998.0	206,813.0	164,815.0
Машин тоног төхөөрөмж	121,878.7	208,991.9	87,113.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	141,251.2	126,712.2	(14,539.0)
Номын фонд	55,217.2	60,096.8	4,879.6
Бусад үндсэн хөрөнгө	1,562,234.4	4,604,433.8	3,042,199.4
Биет бус хөрөнгө	23,447.2	318,167.9	294,720.7
Программ хангамж	554.2	66.7	(487.5)
Бусад биет бус хөрөнгө	22,893.0	318,101.2	295,208.2
Дүн	4,009,308.0	7,566,976.4	3,557,668.4

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 3,557,668.4 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээнээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,781,200.0 мянган төгрөгийн сумын төв доторх 2.5 км автозам, 313,967.4 мянган төгрөгийн хүлэмж, 20,450.0 мянган төгрөгийн 10 ширхэг суурин компьютерыг орлогод авсан,
- Улсын онцгой комиссоос шилжүүлсэн 106,900.0 мянган төгрөгийн автомашин, аймгийн БОГ-аас шилжүүлсэн 5,136.4 мянган төгрөгийн мотоциклийг орлогод авсан,
- Аймгийн ОНХС, ОНХО, Замын сангийн хөрөнгөөр 59,734.5 мянган төгрөгийн 21 ширхэг гудамжны гэрэлтүүлэг, 20,754.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, орлогод авсан,
- Сумын ОНХС, ОНХО-аас хийгдсэн 254,599.2 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг орлогод авсан,
- Сумын 100 жилийн ойн баяртай холбоотойгоор 183,789.7 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан,
- Төсвийн хөрөнгөөр 73,985.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга худалдан авч, 295,208.2 мянган төгрөгийн сумын шинэ суурьшлын бүсийн 13 ширхэг газрыг бүртгэлд авснаас голлон шалтгаалсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 8,920,106.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,376,465.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	278,919.3	278,919.3	-
Хуримтлагдсан үр дүн	4,053,997.5	8,430,463.1	4,376,465.6
Өмнөх үеийн үр дүн	2,966,179.5	4,053,997.5	1,087,818.0
Тайлант үеийн үр дүн	1,087,818.0	4,376,465.6	3,288,647.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	210,724.1	210,724.1	-
Дүн	4,543,640.9	8,920,106.5	4,376,465.6

Эх сурвалж: Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Баруунбүрэн сумын ИТХ-ын “2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 2024 оны 10 дугаар сарын 03–ны өдрийн 94 дүгээр тогтоолоор 786,980.2 мянган төгрөгийн татварын орлого, 38,200.0 мянган төгрөгийн татварын бус орлого зэрэг нийт 825,180.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 1,295,450.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 48.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	786,980.2	1,149,377.1	362,396.9	146.1
Хувь хүний орлогын албан татвар	260,585.6	366,492.2	105,906.6	159.8
Үйл ажиллагааны орлого	109,000.0	159,589.2	50,589.2	146.4
Хөрөнгийн орлого	24,601.2	29,725.4	5,124.2	120.8
Хөрөнгө борлуулсны орлого	12,300.6	2,376.0	(9,924.6)	19.3
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	10,000.0	16,044.9	6,044.9	160.4
Малын тоо толгойн албан татвар	198,658.0	208,685.1	10,027.1	105.0
Бууны албан татвар	1,200.0	1,320.0	120.0	110
Улсын тэмдэгтийн хураамж	10,000.0	14,892.6	4,892.6	148.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	5,000.0	513.8	(4,486.2)	10.3
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3,000.0	2,257.9	(742.1)	75.3
Газрын төлбөр	77,196.9	31,991.7	(45,205.2)	41.4
Газрын дуудлага худалдааны орлого	0.0	210,999.0	210,999.0	-
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	3,412.0	13,608.6	10,196.6	398.8
Байгалийн ургамал ашигласны төлбөр	2,000.0	7,383.4	5,383.4	396.2
Ойн нөөц ашигласны төлбөр	147,222.8	115,489.0	(31,733.8)	78.4
Татварын бус орлого	38,200.0	146,073.1	107,873.1	382.4
Хүү, торгуулийн орлого	28,200.0	33,154.0	4,954.0	117.6
Бусад орлого	10,000.0	112,919.1	102,919.1	264.8
Нийт дүн	825,180.2	1,295,450.2	470,270.0	148.7

Тайлант онд:

- ХХОАТ-ын орлого 105,906.6 мянган төгрөгөөр,
- Үйл ажиллагааны орлого 50,589.2 мянган төгрөгөөр,
- Хөрөнгийн орлого 5,124.2 мянган төгрөгөөр,
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 6,044.9 мянган төгрөгөөр,
- Газрын төлбөр болон дуудлага худалдааны орлого 210,999.0 мянган төгрөгөөр,
- Хүү, торгуулийн орлого 4,954.0 мянган төгрөгөөр
- Малын тоо толгойн албан татвар 10,027.1 мянган төгрөгөөр,
- Бууны албан татвар 120.0 мянган төгрөгөөр,
- Улсын тэмдэгтийн хураамж 4,892.6 мянган төгрөгөөр,
- Бусад орлого 102,919.1 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол,
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж 742.1 мянган төгрөгөөр,
- Хөрөнгө борлуулсны орлого 9,924.6 мянган төгрөгөөр,
- Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 31,733.8 мянган төгрөг,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 4,486.2 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- **Үйл ажиллагааны орлого:** ЭТТ хувьцаат компанийн 2024 оны ногдол ашгаас суутгасан орлогын албан татвар төрийн санд шилжин үйл ажиллагааны орлого 159,589.2 төгрөгийн гүйцэтгэлтэй 46.4 хувьтай давж биелсэн,
- **Цалин хөлс түүнтэй адилтгах орлого:** 105,906.6 мянган төгрөгөөр давж биелсэн нь 2024 оны 4 дүгээр сараас төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнээс шалтгаалсан,
- **Хөрөнгийн орлого:** 5,124.2 мянган төгрөгөөр давж биелсэн нь тайлант онд иргэдийн хадгаламж, хүүхдийн мөнгөний хадгаламж өссөнөөр тухайн орлого 20.8 хувиар давж биелсэн,
- **Үл хөдлөх хөрөнгийн орлого:** Сумын хэмжээнд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийн ногдлыг тулган баталгаажуулж өмнө жилийн өртэй 2 аж ахуйн нэгжийн өрийг шат дараалсан арга хэмжээ авч банкны хаалт хийн барагдуулснаар тайлант оны гүйцэтгэл давж биелэх үндэслэл болсон,
- **Малын тоо толгойн албан татвар:** Өмнөх оны татварын өрийг барагдуулж тайлант оны ногдлыг төлүүлэн шат дараалсан арга хэмжээ авч ажилласнаар өссөн дүнгээр биелсэн,
- **Улсын тэмдэгтийн хураамж:** Тайлант онд аймгийн иргэдийн хурлаас гарсан шийдвэрээр төрийн байгууллагаас иргэдэд үзүүлсэн үйлчилгээний хураамж нэмэгдсэн. Орхон бүсийн сумдын айл өрх нь тус сумын Ойн ангиас түлшний мод бэлтгэх эрх авдаг. Энэ жилийн хувьд дээрх сумдууд хуваарьтай модоо бүрэн бэлтгэсэн нь тухайн орлогын гүйцэтгэл 148.9 хувиар биелэхэд нөлөөлсөн.
- **Газрын дуудлага худалдааны орлого:** 2024 оны орлогын төлөвлөгөөнд тухайн орлого нь тусгагдаагүй,
- **Ан амьтны нөөц ашигласны төлбөр:** 2024 онд гадаадын иргэн, аж ахуй нэгжид 2 ширхэг бор гөрөөсийг дуудлага худалдаа зохион байгуулан агнах зөвшөөрөл олгосон,

- **Байгалийн ургамал ашигласан төлбөр:** Тодотголоор орлогын төлөвлөгөөг бууруулсан боловч цайны ургамлын гарц их байсантай холбоотойгоор гүйцэтгэл 7,383.4 мянган төгрөгөөр буюу 369.2 хувьтай биелсэн,
- **Нэр заагдаагүй бусад орлого:** Тайлант онд Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэсэгтэй хамтран ажиллаж хуш модны самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан бөгөөд түүнээс орсон орлого нөлөөлсөн байна.

Тасарсан орлогууд:

- **Газрын төлбөр:** Орлогын төлөвлөгөөнд 34,500.0 мянган төгрөгөөр тогтоосон боловч тодотголоор орлогын төлөвлөгөөг 77,196.9 мянган төгрөг болгон нэмэгдүүлснээс шалтгаалсан,
- **Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого:** 2024 онд төлөвлөгөөг 147,222.8 мянган төгрөг болж үндэслэлгүйгээр хэт өсгөсөн мөн АИТХ-аас Орхон бүсийн сумдад хуваарилсан түлш болон хэрэглээний модны зөвшөөрөл буурсан, хэрэглээний мод бэлтгэх гэрээ хийсэн нэр бүхий аж ахуй нэгжүүд модоо бэлтгээгүйтэй холбоотойгоор,
- **Хөрөнгө борлуулсны орлого:** Тайлант жилд хөрөнгө борлуулсны орлогын төлөвлөгөөг 12,300.7 мянган төгрөгөөр буюу өмнөх жилүүдээс 2.5 дахин өндөр төлөвлөснөөс шалтгаалан орлого тасарсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 1,223,200.8 мянган төгрөгөөр, татварын болон татварын бус орлогоос 675,663.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 49,300.0 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 14,000.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 583,100.7 мянган төгрөг, ОНХС-н оны эхний үлдэгдлээс 79,189.2 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 91,129.2 мянган төгрөг, ХХС-н оны эхний үлдэгдлээс 37,614.1 мянган төгрөг зэрэг нийт орлого, зарлагыг **2,753,197.8** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 825,180.2 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 49,300.0 мянган төгрөгөөр, урьд оны дансны үлдэгдлээс 114,000.0 мянган төгрөг, ОНХС-аас олгох шилжүүлгийг 607,421.4 мянган төгрөг, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 37,614.1 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 91,129.2 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэг 1,225,565.1 мянган төгрөг зэрэг нийт **3,029,399.3** мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, зарцуулахаар эцэслэн баталсан байна. Үүнд:

Санхүүжүүлэх эх үүсвэрийн өөрчлөлт:

- Үйл ажиллагааны орлогыг 72,098.2 мянган төгрөгөөр,
- Газрын төлбөр 42,696.9 мянган төгрөгөөр
- Малын тоо толгойн албан татварын орлого 19,895.9 мянган төгрөгөөр,

- Хүү торгуулийн орлого 22,672.3 мянган төгрөгөөр,
- Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 2,364.3 мянган төгрөгөөр,
- Аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 24,320.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.
- Хувь хүний орлогын буцаан олголт 5,537.5 мянган төгрөгөөр,
- Байгалийн ургамал ашигласны төлбөр 13,384.3 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Төсвийн зарлагын өөрчлөлт:

- ИТХ-ын урсгал зардлыг 10,000.0 мянган төгрөгөөр,
- ЗДТГ-ын урсгал зардлыг 90,000.0 мянган төгрөгөөр,
- ОНХС-ийн зардлыг 24,320.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос 1,295,450.2 мянган төгрөг, аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 1,225,565.1 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс 114,000.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 597,321.4 мянган төгрөг, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 79,189.2 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын өөрийн орлого 66,898.7 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 33,752.9 мянган төгрөг, ХХС-ийн оны эхний үлдэгдлээс 37,614.1 мянган төгрөг зэрэг нийт **3,449,791.6** мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,364,687.5** мянган төгрөг буюу 78.0 хувьтай тайлагнагдсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 31,061.7 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчийн НДШ-ийн зардал 6,081.9 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 35,834.4 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардал 2,506.0 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардал 364.4 мянган төгрөгөөр,
- Томилолтын зардал 4,448.8 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 93,587.6 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардал 827.8 мянган төгрөгөөр,
- Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 465.9 мянган төгрөгөөр,
- Хөрөнгийн зардал 365,106.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр нийт 23 төсөл, арга хэмжээнд 838,491.3 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, оны эхний үлдэгдэл 125,815.1 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 667,321.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, 473,384.9 мянган төгрөгийг зарцуулан 319,751.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 2 төсөл, огт хэрэгжээгүй, малын тоо толгойн албан татварын орлогоос хэрэгжсэн 7 худаг гаргах төсөл, арга хэмжээ нь гүйцэтгэгчээс шалтгаалан он дамжсанаас шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т *“нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна”* гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДНХ-өөс 522.5 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс 1,451.2 мянган төгрөг, Биеийн тамир спортын газраас 800.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,506.0 мянган төгрөг зэрэг нийт **5,279.7** мянган төгрөг, Ойн ангийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 1,302.1 мянган төгрөг, нийт **6,581.8** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Үүнээс хангамж бичиг хэргийн зардалд 2,232.1 мянган төгрөг, шатахууны зардалд 1,664.9 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1,176.0 мянган төгрөг, урамшуулалд 708.8 мянган төгрөг, спортын арга хэмжээний зардалд 800.0 мянган төгрөг зэрэг нийт **6,581.8** мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд Баруунбүрэн сумын ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэхээр баталсан 11 төсөл, арга хэмжээ, аймгаас эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын 2 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг нийт 19 удаагийн цахим тендерийн урилгыг tender.gov.mn цахим хуудсанд нийтэлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д *“Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана”* гэж заасны дагуу Баруунбүрэн сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн нягтлан бодох бүртгэл хөтлөлт болон үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой зөвлөмж өгсөн болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунбүрэн сумын ТТЗ нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 74 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБООУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 1,854,184.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **18,541.8** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор:

- *Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлсэн,*
- *Тээврийн хэрэгслүүдийг ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар хангасан,*
- *Зайлшгүй шаардлагатай зардлаас бусад зардлыг танасан зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр зардлуудыг хэмнэж, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.*

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтыг зөрчин сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулган хадгалан үлдэх зорилгоор **4,879.6** мянган төгрөгийг “Монголын баялаг өв соёл” ХХК-тай гэрээ байгуулан шилжүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4: “...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	151	146	5	-
2	Засаг даргын Тамгын газар	151	147	4	-
3	Орхон бүсийн сум дундын ойн анги	151	142	9	-
	Нийт дүн	453	435	18	-

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 453 мэдээллээс 435 мэдээллийг хугацаанд нь, 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 10 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан өдрөөр урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулалгүйгээр 50 хувийн урьдчилгаа санхүүжилтэд нийт **100,000.0** мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь “*Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр урьдчилгаа олгосон зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулахаас зайлсхийж гэрээ шууд байгуулах аргын босго үнэд багтаах зорилгоор **140,000.0** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий худаг гаргах төсөл, арга хэмжээг 7 төсөл, арга хэмжээ болгон төлөвлөж, урьдчилгаа санхүүжилт олгон хэрэгжүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, Засгийн газрын 2024 онд батлагдсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1 дэх: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар - Бараа 20.0 сая төгрөг” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилган давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3. ЗДТГ нь шууд худалдан авах босго үнээс давсан **49,485.3** мянган төгрөгийн шатахууны худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь “... нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”, Засгийн газрын 2024 онд батлагдсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1 дэх: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар - Бараа 20.0 сая төгрөг” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаанд босго үнийн журмыг баримтлах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 10 дугаар сарын 26-ны 122 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулан албан хаагчдад спортын хувцас авсан зөрчилд төлбөрийн акт тогтоон, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, төсвийн орлогын төлөвлөгөө тасалсан болон шилэн данстай холбоотой зөрчилд 2 албан шаардлага, анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой 1 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,015.0	1	1,015.0	100
Албан шаардлага	3	45,206.6	3	45,206.6	100
Зөвлөмж	1	12,164.9	1	12,164.9	100
Нийт дүн	4	58,385.5	4	58,385.5	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг уг аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа. Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн” болон “ОНХС-ийн 2024 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **15,432.6** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,618.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10,974.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн 2,840.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт:

1. Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг үндэслэн орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны 2 албан хаагчид олгосон 16,182.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас хувь хүний орлогын албан татварын **1,618.2** мянган төгрөгийг суутгаагүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1: “... урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 22 дугаар зүйлийн 22.1 дэх “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө” 22.1.1: “хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ-ыг нөхөн суутгаж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага:

1. Сумын ЗДТГ-ын даргын албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан нотариатын ажлыг гүйцэтгэсэн гэх үндэслэлээр ЗДТГ-ын дарга Л.Балжиннямд үндсэн цалингийн 40 хувиар тооцож, **7,404.9** мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар

төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, Нотариатын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь “Нотариатч ажилладаггүй сум, тосгонд ... дараах этгээд нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэнэ”, 16.2.1: “сумын Засаг даргын Тамгын газрын дарга, эсхүл тус газрын хуулийн мэргэжилтэн”, сумын ЗДТГ-ын даргын албан тушаалын тодорхойлолтын 5 дугаар зорилтын 4 дэх “сумын хэмжээнд нотариатын үйлчилгээг хууль, журмын дагуу хүргэх, хууль журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тоо, албан тушаалын тодорхойлолтын хүрээнд ажиллагсдын цалин хөлсийг тогтоож байх албан шаардлага хүргүүлэх.

2. Сумын ИТХ нь төлөөлөгчдийн хоолны зардлыг бодит ирцээр бус нийт төлөөлөгчдийн тоогоор тооцож, **569.5** мянган төгрөг илүү зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хоолны зардлыг хуралдааны бодит ирцээр тооцон зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

3. ЗДНХ-өөс жил бүр давтагддаг, урьдчилан төлөвлөх боломжтой, сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны зардал болох тохижилтын ажил буюу нохой устгалд **3,000.0** мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 1.2 дахь “... урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан гэдгийг **жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг ... гэж ойлгоно.**” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж:

1.Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Сумын ЗДТГ нь тайлант онд нийт **2,840.0** мянган төгрөгийн бараа материалыг тухай бүр бичсэн шаардах хуудсаар бус сар бүрийн эцэст бөөн дүнгээр орлого авч, зарлагадсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “... удирдлага, нягтлан бодогч нь ... үйл ажиллагааны

хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалын “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 8.21 дэх “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн байнгын системийг ашиглан бараа материалыг бүртгэнэ”, 8.21.(д) Бараа материалыг ажил, үйлчилгээнд зарцуулах үед: “Бараа материалыг ажил үйлчилгээнд ашиглахаар тавьж олгоход: Дт. Зардал /нэр төрлөөр/, Кт. Бараа материал /нэр төрлөөр/” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр баримтжуулан бүртгэж байх зөвлөмж өгөв.

2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

2.1. Илрүүлэлт: Сумын ЗДТГ нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 22 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д “Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм” ХЗУ4-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй...” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг ашиглах бол дахин үнэлэх буюу актлах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагач эгтгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.
СЭА-2025/012-НА-СТА-ТТЗ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ТТЗ	1	3,000.0			1	3,000.0							
ИТХ	1	569.5			1	569.5							
ЗДТГ	4	11,863.1	1	1,618.2	1	7,404.9	2	2,840.0					
Сумын ТТЗ-ийн дүн	6	15,432.6	1	1,618.2	3	10,974.4	2	2,840.0					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Нийт 18 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	1								1	
Дүн	1								1	
ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжилттэй холбоотой										
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу төлөвлөж, зохион байгуулаагүй	1	289,485.3					1	289,485.3		
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой										
Түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулгасан	1	4,879.6					1	4,879.6		
Дүн	1	4,879.6					1	4,879.6		
Нийт дүн	3	294,364.9					2	294,364.9	1	